

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хүлээгдлийн мэдээний нэгтгэл

/2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар/

1. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Тус эмнэлгээс ирүүлсэн мэдээллээс харахад нийт 15 үйлчлүүлэгч мэргэжлийн эмчид үзүүлэхээр 3-с дээш хоног хүлээж байна. Оношилгооны чиглэлээр эмнэлгийн хүлээгдэл маш их, MRI шинжилгээ хийлгэхээр нийт 190 хүн 15-с дээш хоногийн хүлээгдлэй байна.

2024 оны 5 сард тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй байна. Эмнэлгийн хэмжээнд нийт 1309 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн орны хүлээгдэлтэй байгаа нь өмнөх сартай ойролцоо үзүүлэлттэй байна. Хүснэгт 1.

Хүснэгт 1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Нүд судлал	37	68	72	570	747
2	Чих, хамар, хоолой судлал	9	30	32	304	375
3	Бүдүүн шулуун гэдэсний мэс засал	7	16	36	39	98
4	Урологи	19	18	6	-	43
5	Цусны эмгэг судлал		-	1	-	1
6	Хоол боловсруулах эрхтэн судлал	7	6	4	1	18
7	Дотоод шүүрэл судлал	-	2	-	-	2
8	Мэс засал судлал	12	11	-	-	23
9	Мэдрэл судлал	-	-	2	-	2
	НИИТ	91	151	153	914	1309

Нүд, Чих, хамар, хоолой, Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлэхээр хамгийн их иргэн хүлээж байна. Нүдний тасагт хэвтэн эмчлүүлэхээр 747 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь нийт хүлээгдлийн талаас илүү хувийг эзэлж байна. Мөн хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн 70% нь 1 сараас дээш хугацаагаар ор хүлээж байна.

2. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өмнөх саруудтай ойролцоо хэмжээнд байна. Нийт 109 үйлчлүүлэгч амбулаторийн 7 чиглэлийн кабинетын эмчид үзүүлэхээр 4-с дээш хоног хүлээж байна. Хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж, үйлчилгээнд Хоол боловсруулах эрхтэн судлалын эмчийн үзлэг орж байна. Хүснэгт 2.

Хүснэгт 2. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	2	2	26	30
2	Бөөр судлал	-	7	12	19
3	Мэс засал судлал	-	4	12	16
4	Мэдрэл судлал	-	-	15	15
5	Нүд судлал	2	1	20	23
6	Зүрх судас	-	-	2	2
7	Чих хамар хоолой судлал	4	-		4
	НИЙТ	8	14	87	109

Нийт хүлээгдлийн дийлэнх илүү буюу 80% нь 7-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 35 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сартай адил үзүүлэлттэй байна. Эход харуулахаар 18, рентген оношилгоо хийлгэхээр 12, MRI оношилгоо хийлгэхээр 5 үйлчлүүлэгч тус тус 2-с дээш хоног хүлээж байна. Лабораторийн шинжилгээ хүлээгдэлгүй байна.

Тус эмнэлгийн орны хүлээгдэл өмнөх сараас 30 үйлчлүүлэгчээр буурч, нийт 204 үйлчлүүлэгч 3-с дээш хоног ор хүлээж байна. Мэс заслын тасагт хэвтэхээр 55, Чих, хамар, хоолойн тасагт хэвтэхээр 44 хүн хэвтэн эмчлүүлэхээр тус тус ор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна. Хүснэгт 3.

Хүснэгт 3. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Эмэгтэйчүүдийн эмгэг судлал	5	9	-	-	14
2	Хоол боловсруулах эрхтэн судлал	3	16	10	-	29
3	Чих, хамар, хоолой судлал	-	14	10	20	44
4	Уламжлалт эмчилгээний тасаг	-	-	14	19	33
5	Зүрх судасны эмгэг судлал	-	5	-	-	5
6	Мэс засал судлал	17	23	15	-	55
7	Урологи	-	17	-	-	17
8	Уушиг судлал	1	4	2		7
	НИЙТ	26	88	51	39	204

3. Улсын Улсын гуравдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж үйлчилгээний хүлээгдэл өмнөх саруудтай адил их, 495 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа ба 2024 оны 4 сартай харьцуулахад 83 үйлчлүүлэгчээр буурсан байна. Хүснэгт 4.

Хүснэгт 4. Улсын гуравдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	Нийт
1	Мэдрэл судлал	4	9	78	91
2	Зүрхний эмгэг судлал	4	3	122	129
3	Хоол боловсруулах эрхтэн судлал	-	-	41	41
4	Бөөр судлал	-	5	34	39
5	Булчирхай судлал	3	4	15	22
6	Зүрхний мэс засал судлал	-	1	35	36
7	Нүд судлал	-	-	27	27
8	Уушиг судлал	7	2	2	11
9	Чих хамар хоолой судлал	-	-	23	23
10	Мэс засал судлал	-	1	20	21
11	Мэдрэлийн мэс засал	3	6	6	15
12	Урологи	-	1	17	18
13	Зүрх /хэм алдагдал/	-	-	14	14
14	Сонсгол	-	1	-	1
15	Уламжлалт	1	2	2	5
16	Сэргээн засах	1	-	1	2
	НИЙТ	23	35	437	495

Зүрхний эмгэг судлалын эмчид үзүүлэхээр 129, Мэдрэлийн эмчид үзүүлэхээр 91, 77, Хоол боловсруулах эрхтэн судлалын эмчид үзүүлэхээр 41 үйлчлүүлэгч 3 ба түүнээс дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй үзлэгт хамаарч байна. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 88% (437) нь 7 ба түүнээс дээш хоног хүлээж байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 197 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлттэй адил түвшинд байна. Хүснэгт 5.

Хүснэгт 5. Улсын гуравдугаар төв эмнэлгийн оношилгооны хүлээгдэл

№	Оношилгоо	Хүлээгдлийн хугацаа			Нийт
		3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног	
1	Хэвлийн эхо	-	1	67	68
2	Зүрхний эхо	1	3	51	55
3	Зүрхний цахилгаан бичлэг	1	8	11	20
4	Доплер	-	7	5	12
5	Рентген зураг	2	4	3	9
6	Дуран	-	-	19	19
7	Тархины цахилгаан бичлэг	2	1	-	3
8	Холтер	-	-	11	11
	Бүгд	6	24	167	197

Хэвлийн эхо-д харуулахаар 68 үйлчлүүлэгч, зүрхний эхо-д харуулахаар 55 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй оношилгоонд тус тус хамаарч байна. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 85% нь 15 ба түүнээс

дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Харин тус эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээ хүлээгдэл харьцангуй бага, 41 үйлчлүүлэгч шинэилгээний хүлээгдэлтэй байна. Хүснэгт 6.

Хүснэгт 6. Улсын гуравдугаар төв эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Шинжилгээний нэр	Хүлээгдлийн хугацаа	
		3-6 хоног	7-14 хоног
1	Цусны шинжилгээ	16	-
2	Бактерлогийн шинжилгээ	7	
3	Биохимийн шинжилгээ	10	3
4	Шээсний шинжилгээ	2	
5	Иммунологи	3	
	НИЙТ	38	3

Цусны шинжилгээ хийлгэхээр 16, биохимийн шинжилгээ хийлгэхээр 13 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэл шинжилгээнд хамаарч байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэл ихтэй байгаа ба нийт 139 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь өмнөх сартай ойролцоо үзүүлэлттэй байна. Зүрх судасны тасагт хэвтэн эмчлүүлэхээр 40, Нүдний тасагт хэвтэн эмчлүүлэхээр 28 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь хамгийн их орны хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна. Хүснэгт 7.

Хүснэгт 7. Улсын гуравдугаар төв эмнэлгийн орны хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа хоногийн тоо	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо
1	Мэдрэлийн мэс заслын тасаг	3-6 хоног	5
		7-14хоног	4
		15-30 хоног	3
		1 сараас дээш	2
		Нийт	14
3	Мэдрэлийн тасаг	3-6 хоног	2
		7-14хоног	1
		Нийт	3
5	Нүдний тасаг	3-6 хоног	4
		7-14хоног	10
		15-30 хоног	2
		1 сараас дээш	12
		Нийт	28
6	Чих хамар хоолойн тасаг	3-6 хоног	3
		7-14хоног	14
		Нийт	17
7	Уламжлалт эмчилгээний тасаг	3-6 хоног	7
		7-14хоног	3

		Нийт	10
8	Бөөр судлалын тасаг	3-6 хоног	6
		7-14хоног	10
		Нийт	16
9	Зүрхний мэс засал	3-6 хоног	4
		7-14хоног	5
		15-30 хоног	-
		Нийт	9
10	Зүрх судасны тасаг	3-6 хоног	-
		7-14хоног	40
		15-30 хоног	-
		1 сараас дээш	-
		Нийт	40
11	Мэс заслын тасаг	3-6 хоног	3
		7-14хоног	4
		Нийт	7
	БҮГД	3-6 хоног	27
		7-14хоног	93
		15-30 хоног	5
		1 сараас дээш	14
		Нийт	139

4. Хавдар судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ хүлээгдэл ихтэй байна. Эмчийн үзлэг хийлгэхээр нийт 510 үйлчлүүлэгч 4-с дээш хоногоор хүлээж байна. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 94% /480/ нь 7 ба түүнээс дээш хоногоор хүлээгдэлтэй байна. Хүснэгт 8.

Хүснэгт 8. Хавдар судлалын үндэсний төвийн амбулаторийн хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Амбулаториор үзүүлэхээр хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо		Бүгд
		4-6 хоног	7-с дээш хоног	
1	Эмэгтэйчүүдийн мэс засал	2	58	60
2	Хөхний төв	-	67	67
3	Толгой, хүзүүний мэс засал	-	37	37
4	Элэг судлал	2	39	41
5	Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал	1	49	50
6	Хими	-	68	68
7	Туяа эмчилгээ	-	48	48
8	Ерөнхий мэс засал	7	27	34
9	Ангиографи	1	15	16
10	Зүрх судас судлал	3	19	22
11	Цээжний хөндийн мэс засал судлал	7	11	18
12	Мэдээгүйжүүлэг	6	10	16
13	Дотоод шүүрэл	-	29	29
14	Урологи	-	2	2

15	Хөнгөвчлөх	1	1	2
	Нийт	30	480	510

Хими эмчилгээний эмчип үзүүлэхээр 68, Хөхний төвд үзүүлэхээр 67, эмэгтэйчүүдийн мэс засалд үзүүлэхээр 60 үйлчлүүлэгч 4 ба түүнээс дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн үзлэгт хамаарч байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 4-с дээш хоногоор нийт 106 үйлчлүүлэгч хүлээж байна. КТГ-ийн оношилгоо хийлгэхээр 58, зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 17, эход харуулахаар 8, ходоод дурандуулахаар 8, бүдүүн шулуун гэдэс дурандуулахаар 3, рентгенд харуулахаар 3, зүрхний эход харуулахаар 2 үйлчлүүлэгч тус тус хүлээж байна.

ХСҮТ-ийн лаборатори хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэлтэй, нийт 169 үйлчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байна. Хүснэгт 9.

Хүснэгт 9. Хавдар судлалын үндэсний төвийн орны хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Өдрийн хими	4	15	11	2	32
2	Хими	33	37	19	2	91
3	Ангиографи	1	8	3	-	12
4	Эмэгтэйчүүдийн мэс засал	-	-	-	-	-
5	Элэг, цес, нойр булчирхайн мэс засал	3	3	5	-	11
6	Өдрийн туяа					
7	Хөнгөвчлөх	-	3	7	-	10
8	Толгой, хүзүүний мэс засал	-	-	1	1	2
9	Ерөнхий мэс засал	-	2	1	-	3
10	Дуран	-	-	1	-	1
11	Хөхний төв	1	-	1	-	1
12	Өдрийн сэргээн засах	2	1	3	-	6
	Нийт	44	69	52	5	169

Тус эмнэлэгт хими эмчилгээ хийлгэхээр нийт 91 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид орж байна.

5. Арьсны өвчин судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн болон лабораторийн тусламж, үйлчилгээ хүлээгдэлгүй, хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ хүлээгдэлтэй, нийт 87 үйлчлүүлэгч тусламж, үйлчилгээ авахаар хүлээж байна. Үүнд: Арьс харшлын тасагт хэвтэхээр 73 үйлчлүүлэгч 3-6 хоног, 6 үйлчлүүлэгч 7-14 хоног, MRSA-ийн эсрэг эмчилгээ хийлгэхээр 8 үйлчлүүлэгч 3-6 хоногтус тус хүлээж байна.

6. Хүрээ амаржих газар ТМЭ

Тус эмнэлэг 2024 оны 5 сард хүлээгдэлгүй ажилласан байна.

7. Геронтологийн үндэсний төв

Тус төвийн амбулаторийн тусламж үйлчилгээг 8 үйлчлүүлэгч 4-6 хоног хүлээж байна.

8. ГССҮТ, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Өргөө, Амгалан амаржих газрууд, Эх, хүүхэд, нярайн төв-2, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хүүхдийн төв сувилал болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.